



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/04/НА-СТА-ОНА

ТӨВ АЙМГИЙН БАРИЛГА ЗАХИАЛАГЧ, ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ  
ОНӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [maitsetsegt@audit.gov.mn](mailto:maitsetsegt@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: [gereltekhburtgelaudit02@gmail.com](mailto:gereltekhburtgelaudit02@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

|                                                                           |    |
|---------------------------------------------------------------------------|----|
| 1.Аудитын санал дүгнэлт .....                                             | 3  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....                                   | 5  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                          | 5  |
| 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....                         | 5  |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....                          | 6  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                            | 6  |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....       | 8  |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....                                   | 9  |
| 3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....                                      | 9  |
| 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....             | 9  |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....                                 | 9  |
| 4. Аудитын тайлан .....                                                   | 11 |
| 4.1 Ерөнхий зүйл.....                                                     | 11 |
| 4.2 Дотоод хяналт.....                                                    | 11 |
| 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                           | 12 |
| 4.4 Материаллаг байдал .....                                              | 12 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 12 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл.....                                            | 12 |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                              | 13 |
| 8. Аудитын илрүүлэлт.....                                                 | 13 |
| 8.1 Албан шаардлага .....                                                 | 13 |
| 8.2 Зөвлөмж .....                                                         | 13 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|         |                                               |
|---------|-----------------------------------------------|
| АДБОУС  | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС   | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт    |
| ТӨБЗГ   | Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар     |
| ТӨХК    | Төрийн Өмчит Хувьцаат Компани                 |
| АОУС    | Аудитын Олон Улсын Стандарт                   |
| ТУЗ     | Төлөөлөн Удирдах Зөвлөл                       |
| НДШ     | Нийгмийн Даатгалын Шимтгэл                    |
| ХХОАТ   | Хувь Хүний Орлогын Албан Татвар               |
| НӨАТ    | Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар                |
| ТБОНӨТХ | Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Тухай Хууль  |



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.03.15 № 01/210  
танай -ны № -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд техник хяналт гүйцэтгэх зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

19020414

D 2022/2022 он/ALBAN BICHIG


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар   | Үзүүлэлт                                                                        | /төгрөгөөр/            |                        |
|-----------------|---------------------------------------------------------------------------------|------------------------|------------------------|
|                 |                                                                                 | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| <b>1</b>        | <b>ХӨРӨНГӨ</b>                                                                  |                        |                        |
| <b>1.1</b>      | <b>Эргэлтийн хөрөнгө</b>                                                        |                        |                        |
| 1.1.1           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө                                                 | 19,038,599.84          | 3,145,559.63           |
| 1.1.2           | Дансны авлага                                                                   | 1,752,692.00           | -                      |
| 1.1.3           | Татвар, НДШ – ийн авлага                                                        | -                      | -                      |
| 1.1.4           | Бусад авлага                                                                    | -                      | -                      |
| 1.1.5           | Бусад санхүүгийн хөрөнгө                                                        | -                      | -                      |
| 1.1.6           | Бараа материал                                                                  | 4,018,600.00           | 3,927,320.00           |
| 1.1.7           | Урьдчилж төлсөн зардал/тооцоо                                                   | -                      | -                      |
| 1.1.8           | Бусад эргэлтийн хөрөнгө                                                         | -                      | -                      |
| 1.1.9           | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | -                      | -                      |
| <b>1.1.11</b>   | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>                                                  | <b>24,809,891.84</b>   | <b>7,072,879.63</b>    |
| <b>1.2</b>      | <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>                                                    |                        |                        |
| 1.2.1           | Үндсэн хөрөнгө                                                                  | 37,851,592.10          | 39,072,249.33          |
| 1.2.2           | Биет бус хөрөнгө                                                                |                        | 806,666.66             |
| 1.2.3           | Биологийн хөрөнгө                                                               |                        |                        |
| <b>1.2.10</b>   | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>                                              | <b>37,851,592.10</b>   | <b>39,878,915.99</b>   |
| <b>1.3</b>      | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                                       | <b>62,661,483.94</b>   | <b>46,951,795.62</b>   |
| <b>2</b>        | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>                                                  |                        |                        |
| <b>2.1</b>      | <b>Өр төлбөр</b>                                                                |                        |                        |
| <b>2.1.1</b>    | <b>Богино хугацаат өр төлбөр</b>                                                |                        |                        |
| 2.1.1.1         | Дансны өглөг                                                                    | 10,089,830.00          |                        |
| 2.1.1.2         | Цалингийн өглөг                                                                 | -                      |                        |
| 2.1.1.3         | Татварын өр                                                                     | 3,173,892.32           |                        |
| 2.1.1.4         | НДШ – ийн өглөг                                                                 | 186,144.15             |                        |
| 2.1.1.5         | Богино хугацаат зээл                                                            |                        |                        |
| 2.1.1.6         | Хүүгийн өглөг                                                                   |                        |                        |
| 2.1.1.8         | Урьдчилж орсон орлого                                                           |                        |                        |
| <b>2.1.1.13</b> | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>                                         | <b>13,449,866.47</b>   | <b>-</b>               |
| 2.1.2           | Урт хугацаат өр төлбөр                                                          |                        |                        |
| 2.1.2.1         | Урт хугацаат зээл                                                               |                        |                        |
| 2.1.2.2         | Нөөц /өр төлбөр/                                                                |                        |                        |
| <b>2.1.2.6</b>  | <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>                                            |                        |                        |
| <b>2.2</b>      | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>                                                    | <b>13,449,866.47</b>   | <b>-</b>               |
| <b>2.3</b>      | <b>Эздийн өмч</b>                                                               |                        |                        |
| 2.3.1           | Өмч:-төрийн                                                                     | 1,000,000.00           | 1,000,000.00           |
| 2.3.2           | хувийн                                                                          |                        |                        |
| 2.3.3           | хувьцаат                                                                        |                        |                        |
| 2.3.4           | Халаасны хувьцаа                                                                |                        |                        |
| 2.3.9           | Хуримтлагдсан ашиг                                                              | 48,211,617.47          | 45,951,795.62          |
| 2.3.10          |                                                                                 | -                      | -                      |
| <b>2.3.11</b>   | <b>Эздийн өмчийн дүн</b>                                                        | <b>49,211,617.47</b>   | <b>46,951,795.62</b>   |
| <b>2.4</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>                                           | <b>62,661,483.94</b>   | <b>46,951,795.62</b>   |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                           | /төгрөгөөр/            |                        |
|---------------|------------------------------------|------------------------|------------------------|
|               |                                    | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| <b>1</b>      | <b>Борлуулалтын орлого (цэвэр)</b> | <b>196,645,926.00</b>  | <b>167,220,070.00</b>  |
| <b>2</b>      | <b>Борлуулалтын өртөг</b>          | <b>-</b>               | <b>-</b>               |

**Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

|           |                                                           |                       |                       |
|-----------|-----------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>3</b>  | <b>Нийт ашиг( алдагдал)</b>                               | <b>196,645,926.00</b> | <b>167,220,070.00</b> |
| 4         | Түрээсийн орлого                                          | -                     | -                     |
| 5         | Хүүгийн орлого                                            | -                     | -                     |
| 6         | Ногдол ашгийн орлого                                      | -                     | -                     |
| 7         | Эрхийн шимтгэлийн орлого                                  | -                     | -                     |
| 8         | Бусад орлого                                              | -                     | -                     |
| 9         | Борлуулалт, маркетингийн зардал                           | -                     | -                     |
| 10        | Ерөнхий ба удирдлагын зардал                              | 161,978,617.07        | 167,677,799.85        |
| 11        | Санхүүгийн зардал                                         | 48,840.00             | 49,400.00             |
| 12        | Бусад зардал                                              | 4,193,331.81          | 1,752,692.00          |
| 13        | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)                | -                     | -                     |
| 14        | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                | -                     | -                     |
| 15        | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)              | -                     | -                     |
| 16        | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)           | -                     | -                     |
| 17        | Бусад ашиг ( алдагдал)                                    | -                     | -                     |
| <b>18</b> | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>              | <b>30,425,137.12</b>  | <b>(2,259,821.85)</b> |
| 19        | Орлогын татварын зардал                                   | 3,042,513.71          | -                     |
| <b>20</b> | <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>                    | <b>27,382,623.41</b>  | <b>(2,259,821.85)</b> |
| 21        | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | -                     | -                     |
| 22        | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)                      | 27,382,623.41         | (2,259,821.85)        |
| 23        | Бусад дэлгэрэнгүй орлого                                  | -                     | -                     |
|           | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү               | -                     | -                     |
|           | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү                        | -                     | -                     |
|           | Бусад олз (гарз)                                          | -                     | -                     |
| <b>24</b> | <b>Орлогын нийт дүн</b>                                   | <b>27,382,623.41</b>  | <b>(2,259,821.85)</b> |
| 25        | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)               | -                     | -                     |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                            | Өмч          | Хөрөнгийн дахин үнэлгээ нэмэгдэл | Эздийн өмч бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн       |
|-------------------------------------|--------------|----------------------------------|------------------------|--------------------|----------------|
| 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл |              |                                  |                        | 48,211,617.47      | 48,211,617.47  |
| 2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл |              |                                  |                        | 48,211,617.47      | 48,211,617.47  |
| Залруулсан үлдэгдэл                 | 1,000,000.00 |                                  |                        |                    | 1,000,000.00   |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) |              |                                  |                        | (2,259,821.85)     | (2,259,821.85) |
| 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 1,000,000.00 | -                                | -                      | 45,951,795.62      | 46,951,795.62  |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ                                     | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---------------|----------------------------------------------|------------------------|------------------------|
| 1             | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ        |                        |                        |
| 1.1           | Мөнгөн орлогын дүн (+)                       | 165,188,402.00         | 157,130,240.00         |
|               | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 159,444,969.00         | 157,130,240.00         |
|               | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого    | -                      | -                      |



**Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

|     |                                                                       |                       |                        |
|-----|-----------------------------------------------------------------------|-----------------------|------------------------|
|     | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө                                | -                     | -                      |
|     | Буцаан авсан албан татвар                                             | -                     | -                      |
|     | Татаас, санхүүжилтийн орлого                                          | -                     | -                      |
|     | Бусад мөнгөн орлого                                                   | 5,743,433.00          | -                      |
| 1.2 | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                        | <b>163,268,474.27</b> | <b>158,786,480.21</b>  |
|     | Ажиллагчдад төлсөн                                                    | 88,127,483.00         | 86,136,616.00          |
|     | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                                | 20,406,690.68         | 22,635,177.74          |
|     | Бараа материал худалдан авахад төлсөн                                 | 2,010,860.00          | 5,408,730.00           |
|     | Ашиглалтын зардалд төлсөн                                             | 11,950,645.00         | 2,215,040.00           |
|     | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн                 | 9,346,140.00          | 8,243,210.00           |
|     | Хүүгийн төлбөрт төлсөн                                                | -                     | -                      |
|     | Татварын байгууллагад төлсөн                                          | 7,137,700.61          | 12,080,806.47          |
|     | Даатгалын төлбөрт төлсөн                                              | -                     | -                      |
|     | Бусад мөнгөн зарлага                                                  | 24,288,954.98         | 22,066,900.00          |
| 1.3 | <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>             | <b>1,919,927.73</b>   | <b>(1,656,240.21)</b>  |
| 2   | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>              | -                     | -                      |
| 2.1 | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                                         | <b>11,000,000.00</b>  | -                      |
|     | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого                                      | -                     | -                      |
|     | Биет бус хөрөнгө борлуулсны орлого                                    | -                     | -                      |
|     | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого                                    | -                     | -                      |
|     | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого                          | -                     | -                      |
|     | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт                | 11,000,000.00         | -                      |
|     | Хүлээн авсан хүүгийн орлого                                           | -                     | -                      |
|     | Хүлээн авсан ногдол ашиг                                              | -                     | -                      |
|     |                                                                       | -                     | -                      |
| 2.2 | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                        | -                     | 14,236,800.00          |
|     | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                   | -                     | 13,356,800.00          |
|     | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                 | -                     | 880,000.00             |
|     | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн                                 | -                     | -                      |
|     | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                       | -                     | -                      |
|     | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа                                  | 11,000,000.00         | (14,236,800.00)        |
|     |                                                                       |                       |                        |
| 2.3 | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>11,000,000.00</b>  | <b>(13,356,800.00)</b> |
| 3   | <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                      |                       |                        |
| 3.1 | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>                                         |                       |                        |
|     | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан                   |                       |                        |
|     | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан          |                       |                        |
|     | Төрөл бүрийн хандив                                                   |                       |                        |
|     |                                                                       |                       |                        |
| 3.2 | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                        |                       |                        |
|     | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                          |                       |                        |
|     | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн                                    |                       |                        |
|     | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн                                 |                       |                        |
|     | Төлсөн ногдол ашиг                                                    |                       |                        |
|     |                                                                       |                       |                        |
| 3.3 | <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>         | -                     | -                      |
| 4   | <b>Валютын ханшийн зөрүү</b>                                          |                       |                        |
| 5   | <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                       | 12,919,927.73         | (15,893,040.21)        |



**Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

|   |                                                   |                      |                      |
|---|---------------------------------------------------|----------------------|----------------------|
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | <b>6,118,672.11</b>  | <b>19,038,599.84</b> |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | <b>19,038,599.84</b> | <b>3,145,559.63</b>  |

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

| № | Үзүүлэлт                                        | 2020 оны гүйцэтгэл    | 2021 оны              |                       | Зөрүү                   | Хувь  |
|---|-------------------------------------------------|-----------------------|-----------------------|-----------------------|-------------------------|-------|
|   |                                                 |                       | Төлөвлөгөө            | Гүйцэтгэл             |                         |       |
|   | Техник хяналтын орлого                          | 196,645,926.00        | 380,240,000.00        | 167,220,070.00        | (213,019,930.00)        | 44.0% |
|   | <b>Нийт дүн</b>                                 | <b>196,645,926.00</b> | <b>380,240,000.00</b> | <b>167,220,070.00</b> | <b>(213,019,930.00)</b> | 44.0% |
|   | Цалин хөлс                                      | 93,589,532.00         | 130,792,320.00        | 93,130,301.00         | (37,662,019.00)         | 71.2% |
|   | НДШ-ийн зардал                                  | 10,794,264.00         | 17,656,963.20         | 11,674,713.85         | (5,982,249.35)          | 66.1% |
|   | Албан татвар хураамж /Машины татвар бусад/      | 2,137,645.00          | 5,200,000.00          | 2,345,960.00          | (2,854,040.00)          | 45.1% |
|   | Бичиг хэргийн зардал                            | 2,416,530.00          | 4,495,000.00          | 2,008,569.00          | (2,486,431.00)          | 44.7% |
|   | Ашиглалтын зардал                               | 5,427,990.00          | 0.00                  |                       | -                       | -     |
|   | Хангамжийн материалын зардал                    |                       | 3,031,000.00          | 2,288,992.00          | (742,008.00)            | 75.5% |
|   | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал      |                       | 9,750,000.00          | 9,352,080.00          | (397,920.00)            | 95.9% |
|   | Сургалтын зардал                                | 2,603,300.00          | 7,632,000.00          | 2,575,000.00          | (5,057,000.00)          | 33.7% |
|   | Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/        |                       |                       |                       | -                       | -     |
|   | Тогтмол үйлчилгээ, засвар                       |                       | 6,600,000.00          | 6,568,300.00          | (31,700.00)             | 99.5% |
|   | Шатахууны зардал                                | 10,613,000.00         | 16,992,000.00         | 10,161,260.00         | (6,830,740.00)          | 59.8% |
|   | Даатгалын зардал                                |                       |                       |                       | -                       | -     |
|   | Утас, интернэт                                  | 1,109,900.00          | 4,152,000.00          | 1,168,200.00          | (2,983,800.00)          | 28.1% |
|   | Томилолт /унаа, буудал, хоол/                   | 5,856,000.00          | 11,614,500.00         | 7,508,000.00          | (4,106,500.00)          | 64.6% |
|   | Хэвлэлийн зардал                                |                       | 228,025.00            |                       | (228,025.00)            | 0.0%  |
|   | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал |                       |                       |                       | -                       | -     |
|   | Банкны үйлчилгээний зардал                      | 48,840.00             |                       | 49,400.00             | 49,400.00               | -     |
|   | Цэвэрлэгээний материалын зардал                 | 1,827,580.00          | 1,020,000.00          | 215,830.00            | (804,170.00)            | 21.2% |
|   | Зар сурталчилгааны зардал                       |                       | 4,576,000.00          | 2,344,500.00          | (2,231,500.00)          | 51.2% |
|   | Хөдөлмөр хамгааллын зардал                      |                       | 6,240,000.00          | 218,854.00            | (6,021,146.00)          | 3.5%  |
|   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал  | 13,162,118.00         | 12,499,200.00         | 5,733,790.00          | (6,765,410.00)          | 45.9% |
|   | Сэлбэг хэрэгсэл                                 |                       | 6,375,000.00          |                       | (6,375,000.00)          | -     |
|   | Үндсэн хөрөнгө худалдаж авах зардал             | 12,391,918.00         | 80,000,000.00         | 12,136,142.00         | (67,863,858.00)         | 15.2% |
|   | <b>Нийт дүн</b>                                 | <b>161,978,617.00</b> | <b>328,854,008.20</b> | <b>169,479,891.85</b> | <b>130,818,972.50</b>   | 51.5% |

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үндсэн зорилго нь барилгын ажлын зураг төсөв техникийн норм, дүрмийг дагаж мөрдүүлэх, зөв зохистой төлөвлөн зарцуулах, чанартай материал хийц эдлэлээр барилга бариулах, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино” гэжээ.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээн байгуулалт, барилгын ажлын төсөв, санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах, чанартай материал хийц эдлэлээр барилгыг бариулах, зураг төсөв, техникийн норм дүрмийг дагаж мөрдүүлэх, болон далдлагдах ажлыг шалгаж дутагдлыг засуулах, ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх, барилга байгууламжийг чанартай ашиглалтад оруулахад техникийн хяналт тавих
  - Байгууллага, аж ахуйн нэгжтэй ерөнхий захирагчийн өмнөөс үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого стратеги, төлөвлөлтийг хэрэгжүүлэх
  - Зуунмод хотын газрын нөөцийг үр ашигтай төлөвлөн эргэлтэд оруулах замаар хотын суурьшлын бүсийг хөгжүүлэх, бага дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах, орон сууцны нөхцөлийг сайжруулах, орон сууц нийлүүлэх, ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах
- Аймгийн орон сууц, дахин төлөвлөлтийн асуудлыг нэгтгэн зохион байгуулах, зохицуулах

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ыг Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 121 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” гэсэн заалттай нийцэж байна.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх удирдлагыг Төв аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Б/01 дугаартай тушаалаар томилсон байна.

Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 13 дугаартай тушаалаар Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн гишүүдийн 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01 дугаартай тогтоолоор компанийн 2021 оны бүтэц орон тоог 8 хүнтэй баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт        |
|---------------------------------------------------|-----------------|-----------------|-----------------|
| Б                                                 | 1               | 2               | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                                    | 19,038.6        | 3,145.6         | 15,893.0        |
| Авлага                                            | 1,752.7         | -               | (1,752.7)       |
| Бараа материал                                    | 4,018.6         | 3,927.3         | 91.3            |
| Үндсэн хөрөнгө                                    | 37,851.6        | 39,072.2        | 1,220.6         |
| Биет бус хөрөнгө                                  | -               | 806.7           | 806.7           |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>62,661.5</b> | <b>46,951.8</b> | <b>15,709.7</b> |
| Богино хугацаат өглөг                             | 13,449.9        | -               | (13,449.9)      |
| Эздийн өмч                                        | 1,000.0         | 1,000.0         | -               |
| Хуримтлагдсан ашиг                                | 48,211.6        | 45,951.8        | (2,259.8)       |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>62,661.5</b> | <b>46,951.8</b> | <b>15,709.7</b> |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд Хаан банкны 5721642716 дугаартай харилцах дансны 3,145.6 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Авлагын данс үлдэгдэлгүй болж, 1,752.7 мянган төгрөгөөр буурсан нь Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас авах 1,752.7 мянган төгрөгийн он дамжсан авлагыг тайлант оны найдваргүй авлагын зардалд тусган данснаас хассанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,927.3 мянган төгрөг болж, 91.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 39,072.2 мянган төгрөг болж, 1,220.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Үндсэн хөрөнгийн данс 16 ширхэг 13,356.8 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө худалдан авснаар нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр буурчээ.

Биет бус хөрөнгийн данс 806.7 мянган төгрөг болж нэмэгдсэн нь 880.0 мянган төгрөгөөр Төсвийн программ худалдан авснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөрийн данс үлдэгдэлгүй болж, 13,449.9 мянган төгрөгөөр буурсан нь нийт өр төлбөрийг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Нийт борлуулалтын орлого 167,220.1 мянган төгрөг болж 29,425.8 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь Төрийн сангийн 100140051370 дугаартай хяналтын орлогын дансанд байгууллагын улс болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд хийж гүйцэтгэсэн захиалагчийн хяналтын орлогыг төвлөрүүлж авдаг, байгууллага уг дансаар дамжуулан санхүүждэгтэй холбоотой байна.

Нийт зардал 169,479.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,259.1 мянган төгрөгөөр өссөн нь ерөнхий ба удирдлагын зардал өмнөх оноос 5,699.2 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалжээ.

### 3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 380,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 328,854.0 мянган төгрөгөөр, 51,146.0 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 167,280.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 167,190.9 мянган төгрөгийн зардал гарган, 2,259.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 167,280.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 213,019.9 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төрийн сангийн 100140051370 дугаартай хяналтын орлогын дансанд тус байгууллагын улс болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд хийж гүйцэтгэсэн захиалагчийн хяналтын орлогыг төвлөрүүлж авдаг, байгууллага нь уг дансаар дамжуулан санхүүждэгтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 169,479.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 130,818.9 мянган төгрөгөөр дутуу биелэлттэй байна. Энэ нь 12 хүний орон тоо баталснаас гүйцэтгэлээр 8 хүн ажиллаж цалин, НДШ, ХХОАТ хэмнэгдсэн, үндсэн хөрөнгө худалдан авах зардал өмнөх машины асуудлыг эцэслэн шийдээгүйгээс боломжгүй болсон, Ковид 19 цар тахалтай холбоотой шатахуун, томилолт бусад зардлууд хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант онд цэвэр алдагдал 2,259.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 53,645.8 мянган төгрөгөөр дутуу байгаа нь орлогын гүйцэтгэл 213,019.9 мянган төгрөгөөр тасарсан, зардлын гүйцэтгэл 130,818.9 мянган төгрөгөөр дутуу биелэлттэй байгаагаас шалтгаалжээ.

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдэл болон татварын хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Барилга захиалагч орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан тодруулгыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас дотоод хяналт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт орлого 196,645.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 3,932.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 2,949.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос 2.0 хувиар буюу 3,344.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 2,508.3 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 588.5 мянган төгрөгөөр буурсан байна.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 153,718.8 мянган төгрөгийн 12 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил

тод байршуулахаас 31,344.4 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 6.2. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 242,896.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,257.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 240,638.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Орлогын данстай холбоотой үүссэн асуудал тус байгууллагаас шалтгаалаагүй гэж үзэх магадлалтай тул 209,294.4 мянган төгрөгийн зөвлөмжийг материаллаг бусаар тооцсон болно.

Залруулагдаагүй 2,257.2 мянган төгрөгийн материаллаг алдаа зөрчил нь тогтоосон 2,508.3 мянган төгрөгийн түвшинээс 251.1 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

### 8.1 Албан шаардлага

Байгууллага нь нийт 6 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 2,257.2 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.8-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

### 8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Орлого зардлын данстай холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:



Тайлант 2021 онд Төв аймгийн Төрийн сангийн 100140051370 тоот дансанд тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого болох захиалагчийн техник хяналтын /тухайн ажлын төсөвт өртгийн барилга угсралтын зардлын 2 хувь/ 360,424.6 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс байгууллага нь үйл ажиллагаандаа шаардлагатай 151,130.2 мянган төгрөгийн санхүүжилтийг нэхэмжлэн авсан байна. Байгууллага болон Төрийн сан хоорондын тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй тул санхүүгийн тайланд авлагаар тусгадаггүй байна. Харин байгууллага нь тайлант 2021 онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр өөрийн орлого болох барилга захиалагчийн техник хяналтын орлогоос олох орлогыг 380,240.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 167,220.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 213,019.9 мянган төгрөгөөр буюу 56.0 хувиар тасарсан үзүүлэлттэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т “үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах”, 20 дугаар зүйлийн 20.1.2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **1.2 Зөвлөмж**

Үндсэн үйл ажиллагааны орлого болох захиалагчийн техник хяналтын орлого /тухайн ажлын төсөвт өртгийн барилга угсралтын зардлын 2 хувь/-ийг төрийн сангаас зөвшөөрөл авч зарцуулахтай холбоотой асуудлыг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, хоорондын тооцоог хянаж, авлага өглөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайланд бүртгэн тайлагнах

## ***2. Шилэн данстай холбоотой асуудал***

### **2.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст нийт 153,718.8 мянган төгрөгийн 12 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 31,344.4 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **2.2 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах



Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх  
бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал  
илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| /мянган төгрөгөөр/                                        |                                                               |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                          |           |           |     |     |     |                 |         |                   |     |           |           |
|-----------------------------------------------------------|---------------------------------------------------------------|------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----------|-----------|-----|-----|-----|-----------------|---------|-------------------|-----|-----------|-----------|
| д/д                                                       | Байгууллагын нэр                                              | Аудитын код            | Алдаа зөрчлийн утга                                                                                                                                                                                                                                                                                                           | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга                                                                                                                                                                                                                                                                                          | Нийт алдаа, зөрчлийн дүн |           | Үүнээс    |     |     |     |                 |         |                   |     |           |           |
|                                                           |                                                               |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                          |           | Залруулга |     | Акт |     | Албан шаардлага |         | Хариуцлага тооцох |     | Зөвлөмж   |           |
|                                                           |                                                               |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Тоо                      | Дүн       | Тоо       | Дүн | Тоо | Дүн | Тоо             | Дүн     | Тоо               | Дүн | Тоо       | Дүн       |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар                           |                                                               |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                          |           |           |     |     |     |                 |         |                   |     |           |           |
| 1                                                         | Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ | ТӨА-2022/04/НА-СТА-ОНА | Худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.                                                                                                                                                                                                                                           | Худалдан авалт хийсэн тухай бүр И баримтаар баталгаажуулан данс бүртгэлд тусгах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, татварын хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах                                                                                                                                            | 1                        | 2,257.2   |           |     |     |     | 1               | 2,257.2 |                   |     |           |           |
| 2                                                         | Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ | ТӨА-2022/04/НА-СТА-ОНА | Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны Төв аймгийн Төрийн сангийн 100140051370 тоот дансанд төвлөрдөг, үйл ажиллагаандаа шаардлагатай санхүүжилтийг нэхэмжлэн Төрийн сангийн зөвшөөрлөөр зарцуулдаг бөгөөд хоорондын тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй байна. Байгууллагын орлогын төлөвлөгөө тасарсан байна. | Үндсэн үйл ажиллагааны орлого болох захиалагчийн техник хяналтын төрийн сангаас зөвшөөрөл авч зарцуулахтай холбоотой асуудлыг холбогдох хууль эрх зүйн актын хүрээнд дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, хоорондын тооцоог хянаж, авлага өглөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайланд авлагаар тусгаж бүртгэх | 1                        | 209,294.4 |           |     |     |     |                 |         |                   | 1   | 209,294.4 |           |
| ДҮН                                                       |                                                               |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 2                        | 211,551.6 |           |     |     |     | 1               | 2,257.2 |                   |     | 1         | 209,294.4 |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал |                                                               |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                          |           |           |     |     |     |                 |         |                   |     |           |           |
| 1                                                         | Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ | ТӨА-2022/04/НА-СТА-ОНА | Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна.                                                                                                                                                                                                                                                       | Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлж хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах                                                                                                                                                                                   | 1                        | 31,344.4  |           |     |     |     |                 |         |                   |     | 1         | 31,344.4  |
|                                                           | ДҮН                                                           |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 1                        | 31,344.4  |           |     |     |     |                 |         |                   |     | 1         | 31,344.4  |
| НИЙТ ДҮН                                                  |                                                               |                        |                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 3                        | 242,896.0 |           |     |     |     | 1               | 2,257.2 |                   |     | 2         | 240,638.8 |